

# Нийгмийн тухай мэдлэг

**БАГШ:Д.ОЮУН**

# Сэдэв 7: Эдийн засгийн амьдрал

Сэдвийн зорилго: Нийгэм эдийн засгийн амьдрал, түүний онцлог, эдийн засгийн тухай ойлголт болоод түүний хэлбэр, бүрдүүлэгч гол элементүүдийн талаар цэгцтэй мэдлэг олж авахад оршино.

# Түлхүүр үгс:

- Меркантилизм
- Физиократизм
- Зах зээл
- Хэрэгцээ
- Нөөц
- Өмч
- Өрсөлдөөн
- Монополь
- Олигополь
- Ажилгүйдэл
- Хамгаалал
- Мөнгөний бодлого

# Эдийн засаг нь

**Oikos-** өрхийн аж ахуй **homos-** хууль гэсэн утгатай грек үг  
Аж ахуй эрхэлж үйлдвэрлэл явуулан тэр баялгийг бүтээн бий болгож, хамгийн чухал эн тэргүүний хэрэгцээгээ хангаж буй хүний үйл ажиллагааны энэ талыг эдийн засгийн амьдрал гэнэ.

Аливаа эдийн засгийн нэгийг сонгох нь нөгөөгөөсөө татгалзахад хүргэнэ. Ингэж татгалзсанаар тодорхой ашигт чанарыг алдана гэсэн үг. Ийнхүү алдаж байгаа ашигт чанарыг алдагдсан боломжийн өртөг гэж нэрлэдэг. Аливаа үйл ажиллагааны алдагдсан боломжийн өртөг бол та өөрийнхөө илүү сайн олж чадах боломжоосоо арга буюу татгалзсанаар гарч байгаа өртөг гэсэн үг.

# Эдийн засгийн онол, ҮҮСЭЛ ХӨГЖИЛ

## Меркантилизм.

Эдийн засгийн үзэгдэл, хууль зүй тогтлыг танин мэдэх гэсэн анхны системтэй оролдлого меркантилизм (худалдаачин гэсэн утгатай латин үг) юм. Гол төлөөлөгчид нь У. Петти, Ж.Стюарт, Б.Кольберг нар юм. Меркантилистууд гадаад худалдааны бодлогын онолын үндэслэлийг боловсруулж, дотоод зах зээлээ хамгаалах, экспортыг урамшуулахын ач холбогдлыг тодорхойлсон

## Физиократизм.

(Байгалийн засаглал гэсэн утгатай грек уг). Тэдний гол төлөөлөгчид нь Ф.Кенэ, В.де Мирабо П.Ревииере, П.де Неммур, А.Де Тюрго, И.Шлеттвайн нар юм. Тэд меркантилистуудыг шүүмжлэн худалдаа арилжаа нь ямар ч баялгийг бүтээдэггүй тэнд ашиг бий болдоггүйг нотолж, улс орны баялаг зөвхөн ХАА, газар тариаланд бүтээгддэг, тариаланчдын хөдөлмөр л бүтээлч хөдөлмөр гэж үзэж байв.



## Сонгодог эдийн засгийн ухаан

А. Смит, Давид Рикардо нарын онол нь эдийн засгийн суурь ухааны үндэс болсон учраас сонгодог онолчид хэмээн нэрлэдэг ажээ. А.Смит хөдөлмөрийн хуваарийн нөхцөлд хүмүүс зөвөн хувийн ашиг хонжоог хайж аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа нь тэднээс үл шалтгаалах бодит хуулиар зохицуулагдаж байдаг, түүнийг үл үзэгдээ гар гэж нэрлэжээ. А.Смитийн үзэл санааг шууд залгамжлан гарч ирсэн хүн бол Д.Рикардо байв. Тэрээр Смитийн өртгийн хөдөлмөрийн онолыг баримтлан туйлын өртөг гэсэн ойлголтыг бий болгосон, мөн гадаад худалдааг гүнзгийрүүлэн судалж “Харьцангуй давуу талын онолоо боловсруулсан байна.




## Шинэ сонгодог онол.

### А) Эдийн засгийн сонгодог сургаалийн чиглэл

К.Маркс. Сонгодог онолчдын бий болгосон өртгийн хөдөлмөрийн онолыг үргэлжлүүлэн ажилчны бүтээсэн хөлсний хөдөлмөрийг капиталист мөлжих замаар ашгийг бүтээдэг талаар дүгнэлт хийж, ингэж олсон ашгийг Маркс "нэмүү өртөг гэж нэрлэсэн байна.


### Б) Шинэ сонгодог чиглэл

Нэмүү өртгийн алдаатай үндэслэлийг илрүүлэн шүүмжлэх нөгөө талаас нийгмийн эдийн засгийн харилцааг зөвхөн өртгийн хөдөлмөрийн онолын үүднээс тайлбарлахаас татгалзаж, “аливаа материаллаг баялгийн үнэ цэн нь түүнийг үйлдвэрлэхэд зарцуулсан хөдөлмөрийн тоо хэмжээгээр биш түүний хүнд өгч буй ашиг чанараар нь хэмжигдэнэ гэжээ.



## Монетаризм.

Кейнсизмыг баримтлагчид "зах зээлийн эдийн засгийн салшгүй шинж болох түүний тогтворгүй байдлыг арилгахад төрийн оролцоо зайлшгүй" гэдэг бол монетаризмийн чиглэлийнхэн "зах зээл дотоод мөн чанар, хөдөлгөх хэмжүүрээрээ тогтвортой байдал руу тэмүүлнэ. Энэ - тогтвортой байдлыг бий болгох механизм өрсөлдөөн бөгөөд цэвэр буюу төгс өрсөлдөөн бол тогтвортой байдлын өндөр зэргийг хангана" гэж үздэг. Тэрчлэн эдийн засгийн тогтворжилт, ажил эрхлэлтийг хангахад - мөнгө-зээлийн бодлогыг гол арга болгон дэвшүүлдэг эдийн засгийн онол юм. Өөрөөр хэлбэл, энэ нь үйлдвэрлэл, үнэ, ажил эрхлэлт, эдийн засгийн тогтворжилтын гол хэрэгсэл байдаг гэж үздэг



## Кейнсизм.

Кейнс эдийн засгийн хямрал болон ажилгүйдлийг зах зээл аяндаа өөрөө үгүй хийж чадахгүй гээд - төрийн зохицуулалтаар эдийн засгийн үр өгөөжтэй хөгжлийг хангаж болно гэсэн зарчмын шинэ санааг <<Ажил эрхлэлт, хүү мөнгөний ерөнхий онол» (1936) гэдэг алдарт бүтээлдээ үндэслэн тавьсан байна. Түүний энэхүү үндэслэлийг эдийн засгийн шинжлэх ухаан дахь «Кейнсийн хувьсгал» хэмээдэг.

# Эдийн засгийн үндсэн асуудал ба ангилал

Хэнд? -Хуваарилалт

Юуг?- Зах зээл

Яаж?- Үйлдвэрлэл

- Натураль буюу амиа аргацаасан эдийн засаг
- Зах зээлийн эдийн засаг
- Төвлөрсөн эдийн засаг

## Макро эдийн засаг

Эдийн засгийн үр ашиг, үнийн түвшин, нийгмийн хамгаалал, худалдааны тэнцвэр, улс хэмжээний эдийн засгийн өсөлт, мөнгөн, санхүү, инфляци, ажил эрхлэлт зэрэг тогтолцооны шинжтэй томоохон үзэгдлийг судална.

## Микро эдийн засаг

Өрх гэр, пүүс, засгийн газар зэрэг эдийн засгийн нэгж хэсгүүд, зах зээлийн субъектүүд мөн өрсөлдөөн, үнэ, эрэлт, нийлүүлэлт зэргийн судална.

# Төвлөрсөн төлөвлөгөөт ба зах зээлийн ялгаа

<p><b>Бүтээгдэхүүний үнэ бүрдэлт</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүх үнийг төр тогтооно</li> <li>- Стратегийн ач холбогдолтойгоос бусдыг нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлт тогтооно</li> </ul>	<p><b>Хүн амын амьдралын баталгаа</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүх хүн тэгш</li> <li>- Хүн өөрийгөө хариуцах</li> </ul>
<p><b>Өмчийн хэлбэр</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын өмч</li> <li>- Хувийн өмч</li> </ul>	<p><b>Банкны систем</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нэг шатлалтай улсын банк</li> <li>- Хоёр шатлалтай арилжаа ба төр</li> </ul>
<p><b>Төлөвлөгөө</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Улс өмнөөс хийдэг</li> <li>- Стратегийн ач холбогдолтойгоос бусдыг байгууллага өөрөө хийнэ.</li> </ul>	<p><b>Бизнесийн ашиг сонирхол</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Бизнес хийвэл гэмт хэрэг</li> <li>- Эдийн засгийн эрх чөлөөтэй, ашиг олох зорилготой</li> </ul>
<p><b>Эдийн засгийн удирдлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгэм эдийн засгийн бүх үйл ажиллагааг төр хариуцна</li> </ul>	<p><b>Төвлөрсөн төлөвлөгөөт</b> <b>Зах зээлийн</b></p>

# Зах зээлийн төрийн үүрэг

- Эдийн засгийн амьдралд хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлэх үүрэг
- Нөөцийг хуваарилах үүрэг
- Төгс өрсөлдөөн өрнөх таатай нөхцлийг бүрдүүлэх үүрэг
- Орлогыг дахин хуваарилах үүрэг
- Эдийн засгийг тогтворжуулах үүрэг

# Эдийн засгийн ТОГТОЛЦООНЫ ХЭВ МАЯГУУД

Хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд хязгаарлагдмал нөөцийг хуваарилахад ашиглаж буй зохион байгуулалтын уялдаа зохицол юм



Чөлөөт зах зээлийн тогтолцоо- Үндсэн шинж нь хувийн **ӨМЧ** юм.

Захиргаадалтын эдийн засгийн тогтолцоо- Энэ тогтолцоонд бараг бүх материаллаг нөөц, үйлдвэрийн газар нь нийтийн (**улсын**) өмч байна.

Холимог эдийн засгийн тогтолцоо- капитализм ба захиргаадалтын эдийн засаг хоёрын нийлмэл тогтолцоо.

Уламжлалт эдийн засгийн тогтолцоо- Туршлага, зан заншил, уламжлалдаа тулгуурласан.

# Эдийн засаг дахь төрийн оролцоо

1. Маш хязгаарлагдмал төр
2. Хамгийн их оролцоотой төр
3. Завсрын оролцоотой төр

# Хэрэгцээний ангилал

- Амь зуух хэрэгцээ-материаллаг буюу анхдагч
- Соёлын хэрэгцээ- хоёрдогч буюу оюун санааны
- Тансаг хэрэгцээ-хоёрдогч буюу оюун санааны

1. Нийгмийн
2. Бүлгийн
3. Хувийн

# Нөөц

Үйлдвэрлэл явуулахад шаардлагатай байгалийн баялаг, ажиллах хүч, багаж, тоног төхөөрөмж

1. Төхөөрөмж
2. Хөдөлмөр
3. Капитал
4. Үйлдвэрлэл эрхлэх үр чадвар

Нөөцийг хэрэглэх зорилгынх нь үүднээс ангилсан нь

- Хэрэглээний нөөц
- Үйлдвэрлэлийн нөөц

# Өмч, түүний харилцаа

Аливаа этгээдэд байж болох, үнэлж болох бүхэн буюу материаллаг болон оюун санааны үнэ цэнтэй зүйл бүхнийг өмч гэнэ.

- ❖ Ашиглах
- ❖ Эзэмших
- ❖ Захиран зарцуулах
- ❖ Үйлдвэрлэх
- ❖ Хуваарилах

Баялгийг өмчлөх явцад хүмүүсийн хооронд үүсэх эдийн засгийн харилцааг өмчийн харилцаа гэнэ.

# Өмчийн хэв маяг, хэлбэрүүд

1	Нийтийн өмч	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн</li> <li>- Орон нутгийн</li> <li>- Олон нийт, сан</li> <li>- Шашны</li> </ul>
2	Хувийн өмч	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрөө хөдөлмөрлөдөг</li> <li>- Боол эзэмшигчийн өмч</li> <li>- Феодлын өмч</li> <li>- Хувь хүний өмч</li> </ul>
3	Холимог өмч	<ul style="list-style-type: none"> <li>- Хувьцаа (акци)</li> <li>- Хоршооллын</li> <li>- Аж ахуйн нөхөрлөл</li> <li>- Хамтын үйлдвэр</li> </ul>

# Эрэлт, нийлүүлэлт ба зах зээлийн үнэ

## Эрэлт

- Худалдан авах чадвараар баталгаажсан хэрэгцээ.

## Нийлүүлэлт

- Тодорхой хугацаанд зах зээлд борлуулахаар нийлүүлж байгаа барааны тоо хэмжээ

Эрэлт нийлүүлэлтэд нөлөөлөх хүчин зүйлс нөлөөлөх хүчин зүйлс :  
эрэлт-Цалин орлого, Хүсэл таашаал, Бусад барааны үнэ

нийлүүлэлт- Бусад орцны, Орцын үнэ, Технологи

## Орлогоос хамаарч эрэлт нь өөрчлөгдөх бараа

**Хэвийн онцгой**- Орлого өсөх/буурах/-д эрэлт нэмэгддэг/буурдаг/

**Дорд бараа**-Орлого өсөх/буурах/-д эрэлт буурдаг /өсч/

Гиффен бараа-Үнэ нь буурах/өсөх/-д эрэлт нь буурч/өсч/

## Үнэ

Солилцооны явцад эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр тодорхойлогч мөнгөн үнэлэмжийг үнэ гэнэ.

- Үйлдвэрлэлийн үнэ -
- Бөөний үнэ-
- Жижиглэнгийн үнэ-

Нэрлэсэн үнэ

- Цэс, лавлах, биржийн үнэлгээ,  
ханш

Монополь үнэ

- Нийлүүлэгч бараандаа  
үйлдвэрлэлийн үнээс хэт дээр, доор  
тогтоосон

Тэнцвэрийн үнэ

- Эрэлт нийлүүлэлтийн харьцаа  
тэнцэж байгаа үнэ



# Өрсөлдөөн

Ашиг сонирхлоо хангахын төлөө аж ахуй эрхлэгчдийн тэмцэлдээнт харилцааг өрсөлдөөн гэнэ.

## Агуулгаар нь

Эргэлтийг бий болгох өрсөлдөөн

Борлуулалтын өрсөлдөөн

Үнийн өрсөлдөөн

Технологийн өрсөлдөөн

## Хэлбэрээр нь

Салбар доторх өрсөлдөөн

Салбар хоорондын

Эдийн засгийн ерөнхий өрсөлдөөн

# Зах зээлийн төлөв байдлууд

Зах зээлийн төлөв байдлын үндсэн шинжүүд	Чөлөөт төгс өрсөлдөөнт зах зээл	Цэвэр монополь	Олигополь	Монопольт өрсөлдөөн
Бүтээгдэхүүн үйлдвэрдэгч пүүсүүдийн тоо	маш олон	Ганц том	Хэд хэдэн том	Хангалттай олон
Бүтээгдэхүүний ижил болон ялгаатай байдал	Нэгэн төрлийн бүтээгдэхүүн олноор үйлдвэрлэдэг	Ойролцоо орлуулах бүтээгдэхүүн байхгүй	Нэгэн төрлийн бүтээгдэхүүн , олноор	Ялгавартай бүтээгдэхүүн
Үнийг хянах	Үнийг зах зээл тодорхойлно	Үнийг үйлдвэрлэгч тодорхойлно	Үнийн манлайлах нөлөө байдаг	Үнийн нөлөөлөл хязгаарлагдмал
Салбарт шинээр ороход учрах бэрхшээл	Харьцангуй хөнгөн, хялбар	Маш хүнд	Хүнд	Орж гарах боломжтой
Үнийн бус өрсөлдөөн	Төгс мэдээлэлтэй	Үнийн бус өрсөлдөөн байхгүй	Үнийн бус өрсөлдөөн хүчтэй	Үнийн бус өрсөлдөөн хүчтэй

# Нийгмийн амьдралд соёлын гүйцэтгэх үүрэг

Соёлын хүмүүжил боловсролын үүрэг	Бие хүн нийгэмших тусмаа иргэн, нийгмийн гишүүн болдог. Өөрөөр хэлбэл өөрийн ард түмэн, нийгмийн бүлэг, хүн төрөлхтний хэл, билэг тэмдэг, үнэт зүйл хэм хэмжээ, ёс заншил, уламжлалыг эзэмшдэг.
Соёлын нэгтгэгч ба салгагч үүрэг	Соёлыг эзэмшсэнээр хүмүүст аль нэг үндэстэн, ард түмэн, шашин, бүлэгт харъяалагдсанаа ухаарах мэдрэмж төрдөг. Ингэснээр хүмүүсийг нэгтгэх, тэдний нийгмийн нэгдмэл байдлыг хангадаг байна.
Соёлын зохицуулагч үүрэг	Нийгэмшлийн үйл явцад үнэт зүйл, чин эрмэлзлэл, зан төрхийн хэм хэмжээ ба хүний өөрийн ухамсрын хэсэг болон төлөвшдөг.

# Хөдөлмөрийн зах зээл

Ажиллах хүчнийг худалдах, худалдан авах субъектын хоорондын харилцааны хүрээг хөдөлмөрийн зах зээл гэнэ.

## ХӨЛСНИЙ АЖИЛЧИН—ҮЙЛДВЭРИЙН ЭЗЭН

Хөдөлмөрийн зах зээлийн үүрэг

- Ажиллах хүчийг бэлтгэх
- Орлогын боломж, амь зуух баталгааг хангах
- Хөдөлмөрийн эрэлт нийлүүлэлтийг зохицуулах

# Ажилгүйдэл

Ажилгүйдэл бол хөдөлмөрийн зах зээл дээрх мөчлөгт үзэгдэл бөгөөд ажиллах хүчний эрэлтээс нийлүүлэлт давснаар бий болдог.

Ажилгүйдлийн түвшин = Нийт ажилгүйчүүдийн тоо / ЭЗ-ийн идэвхитэй хүн ам буюу ажиллах хүч \* 100%

Хэвийн ажилгүйдэл: ажилгүйдлийн түвшин 1-3% байх

Ердийн ажилгүйдэл: ажилгүйдлийн түвшин 5-6% бүрэн ажил эрхлэлт

Хэт ажилгүйдэл: ажилгүйдлийн түвшин 7%-иас дээш байх

# Ажилгүйдлийн хэлбэр

Завсарын (шилжилтийн)- Нэг ажлаас нөгөө ажилд шилжих

Бүтцийн (байнгын)- Нэг салбар, мэргэжлийн цар хүрээ хумигдан, шинэ салбар, мэргэжлийн шаардалага өссөнтэй холбоотой ажилгүйдэл

Мөчлөгийн (циклийн)- Эдийн засгийн уналтын үед бий болдог ажилгүйдэл



## Ажилгүйдлийг бууруулах арга зам

<p>Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, цалин, хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйлдвэржүүлэх</p>	<p>- Хөдөлмөрийн биржийн албыг бэхжүүлэх, мэдээллийн сүлжээ бий болгох, сургалт зохион байгуулах, хүн амын шилжилт хөдөлгөөнд хяналт хязгаарлалт бий болгох</p>	<p>- Ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хамтарсан хөрөнгө оруулалт хийх, ажилллах хүч экспортлох, гадаад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах</p>
<p>Эдийн засгийн-</p>	<p>Захиргааны аргаар</p>	<p>Гадаад хүчин зүйлсийг ашиглах аргаар</p>

# Ядуурал

Амьдралын хэвийн хэрэгцээг хангаж чадахгүй байгааг илэрхийлсэн ойлголт	
Хүнс тэжээлийн ядуурал	Хэрэглээний нийт зардалд хүнс тэжээлийн нийт зардал бүүрах явдал
Хэрэгцээний ядуурал	Ядуучууд бусдаас хэрхэн доогуур амьдарч байгааг харуулах үзүүлэлт
Үнэлгээний ядуурал	Хуулийн дагуу хэнийг ядуу гэж үзэх тооцох үнэлгээний хэмжээ
Амжиргааны доод түвшин	Хүний хэрэглээний доод түвшинг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдал
Харьцангуй ядуу	Дэлхийн банкны тогтоосон амьжиргааны доод түвшинг давахгүй байгаа
Нэн ядуу	Ядуугийн доод түвшин
Туйлын ядуу	ЗГ-с тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшнээс 40%-иас доош
Ядуурлын босго	Хувь хүн, гэр бүл хооол хүнс хувцас, сууцтай байхад хүрэлцэхүйц орлого гэж ЗГ-с тогтоосон
Ядуурлын коэффициент	Ядуурлын босгон доор амьдарч байгаа хүн амын эзлэх хувь

# Нийгмийн хамгаалал

Нийгмийн хамгаалал гэдэг нь нийгмийн бүх гишүүдийн амьдралын хэвийн нөхцлийг хангахад чиглэгдсэн улс төр, эдийн засаг, эрх зүйн харилцааны цогцийг хэлнэ

Өргөн утгаараа хүний хөгжлийг хангах төрийн бодлогын цогц арга хэмжээ

Нийгмийн даатгалын сан бүрдүүлэгч

- Даатгуулгчийн өөрийн төлөх шимтгэл
- Ажил олгогчоос төлөх шимтгэл
- Төсвийн дотаци

Явцуу утгаараа нийгмийн эмзэг бүлгийн амьдрах баталгааг хангах төрийн тусламж, хамгааллын бодлого

Нийгмийн халамж үйлчилгээ

- Улсын төсөв
- Гадаадын зээл, тусламж, хандив

## Даатгалын сангууд

- Тэтгэврийн
- Тэтгэмжийн
- Үйлдвэрийн ослын
- Ажилгүйдлийн
- Эрүүл мэндийн

## Халамжийн тэтгэвэр

- тэтгэвэр
- тэтгэмж

## Халамжийн үйлчилгээ

- Өндөр настны хөнгөлөлт
- Тахир дутуугийн хөнгөлөлт

# Мөнгө, түүний хэлбэр, төрөл, үүрэг

Зах зээлд бусадд бүх таваарыг төлөөлж чадах онцгой төрлийн  
таваарыг мөнгө гэнэ

Таваар-Металл-Зоосон-Тэмдэгт-Дансны-Компьютерийн

## Үүрэг

- Гүйлгээний хэрэгсэл
- Өртгийнэ хэмжүүр
- Хуримтлал хадгалуурын хэрэглүүр

# Мөнгөний бодлого

**Төв банк мөнгөний бодлогыг гаргана.**

**Зорилго:** Мөнгөний тогтвортой байдлыг хадгалах

**Арга хэрэгсэл:** Хүүгийн бодлого, заавал байх нөөцийн хэмжээ, нээлттэй 33-ийн ажиллагаа  
Үүнээс Инфляци болон дефляци үүснэ.

Инфляци- Мөлхөө, цогио, хэтрүү /шалтгаанаар нь/

Хэвийн, зохисгүй /илрэх байдлаар нь/

Эрэлтээс үүдэлтэй, зардлаас үүдэлтэй /үнийн өмөлтөөс хамааруулж/

Дефляци- Үнийн ерөнхий түвшин буурсаныг хэлнэ.

Далд инфляци- Барааны хомсдол, хүн амын орлогын дутагдал

Ил инфляци- Төрийн мөнгөний бодлогоос хамаарч байна.

# Банк, санхүү

Санхүү- Үндэсний нийт орлогын хуваарилалтын үндсэн дээр мөнгөн хөрөнгийг бүрдүүлэн ашиглах эдийн засгийн харилцааны нийгэмл бий болсон харилцаа юм.

- Аж ахуйн субъектуудын санхүү

Хуулийн этгээд, төр хуулийн этгээдүүдийн хоорондийн санхүүгийн харилцаа

- Төрийн санхүү

Улсын төсөв, төсвийн гадуурх улсын сангууд, улсын нийгмийн даатгал, улсын эд хөрөнгийн даатгал хамаарна.

Банк- Мөнгөн хөрөнгө хуримтлуулж зээл олоход, цаасан мөнгө, үнэт цаасны тооцоо хийх, алт гадаад валютын солилцоо, мөнгөн хураамж, бусад үйлчилгээ эрхэлдэг эдийн засгийн байгууллага.

- Өмчийн хэлбэрээс- Хувийн, хоршооллын, олон нийтийн, төрийн улсын, олон улс
- Гүйлгээний үүрэг шинжээс нь хамаарч- Төв банк, арилжааны банк, тусгай банк

# ЗЭЭЛ

Банк нь харилцагч, хадгаламж эзэмшигчийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээс тодорхой зориулалтаар, хүү, хугацаатай, барьцаа батлан даалттайгаар өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд олгож байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

## Зээлийн зарчмууд

- Хугацаатай
- Зорилго чиглэлтэй
- Эргэж төлөгдөх
- Хүүтэй
- Барьцаа, баталгаатай байх

# Улсыг төсөв , түүний үүрэг

**Улсын төсөв**- Тоон утганд оруулсан улсын орлого зарлагын үйл ажиллагааны хөтөлбөр мөн.

Улсын төсөв Орон нутгийн төсөв

- Урсгал орлого: Татварын орлого, татварын бус орлого
- Урсгал зарда: Хөрөнгийн зардал, Эргэж төлөгдөх цэвэр зээл

Үүрэг:

**Улс төрийн үүрэг**- Улсын төсөв боловсорсноор ЗГ-ын үйл ажиллагааны чиглэл тодорхой болж албан ёсоор батлагдана.

**Эдийн засгийн үүрэг**- Улсын төсөв боловсорсноор нийгмийн хамтын хэрэгцээг хангах бололцоотой болдог.

**Хяналтын үүрэг**- Төрөөс улс орны санхүү эдийн засгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй хянах боломжтой болдог

# Татвар, түүний зарчим, төрөл

Хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдүүд болон иргэдээс авч байгаа төрийн хураамжийг татвар гэнэ.

- Албан татвар- заавал төлөх төлбөрийг ААН, иргэд төлнө
- Хураамж- үйлчилгээ үзүүлсний төлөө авдаг
- Төлбөр- төрийн өмчийг ашиглуулсны төлөө

## Татварын зарчим

- Төлөхөөс үл зайлсхийх
- Хэмжээ, төрөл нь тогтвортой байх
- Энэрэнгүй, шудрага байх
- Тогтоосон хугацаатай байх
- Хуульчлагдсан байх
- Тэнцүү ачаалалтай
- Хариу төлбөргүй

# Татварын төрлүүд

## Төсөвт төлөх эх үүсвэрийн хувьд

- Орлогын татварт: ААН, байгууллагын орлогын албан татвар
  - Хүн амын орлогын албан татвар
  - Нийгмийн даатгалын шимтгэлийн татвар
- Хөрөнгийн татварт: Үл хөдлөх хөрөнгийн татвар
- Дотоод бараа, үйлчилгээний татварт: НӨАТ
  - Онцгой албан татвар /архи, тамхи/
  - Тусгай зориулалтын орлогын татвар
    - /автобинзен, дизел/
- Гаалийн татвар: Импортын болон экспортын татвар

# Татварын төрлүүд

## Төсөвт төлөгдөх хэлбэрийн хувьд

- Шууд: иргэн, аж ахуйн нэгжээс завсрын ямар нэг шат дамжлагагүйгээр, орлогынх нь хэмжээтэй уялдуулан тогтоодог. Орлогын албан татвар, үл хөд
- Шууд бус : завсрын ямар нэг шат дамжих замаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, барааны борлуулалттай уялдуулан тогтоодог. НӨАТ, худалдан авагч, үйлчлүүлэгчээс авдаг татвар...

## Төсөвт төвлөрөх байдлын хувьд

- Улсын татвар
- Орон нутгийн татвар

## Ногдуулах хувь хэмжээгээр нь

- Өсгөн нэмэгддүүлэх буюу прогрессив
- Хувь тэнцүүлсэн буюу пропорциональ
- Өсгөн бууруулах буюу регрессив

# Үндэсний эдийн засгийн үзүүлэлтүүд

**ҮНБ**- тодорхой хугацаанд /нэг жилд/ бүтээгдсэн

**ДНБ**- тодорхой хугацаанд тухайн улсын нутаг дэвсгэр дээр бүтээгдсэн эцсийн бүтээгдэхүүн үйлчилгээний мөнгөн дүнг хэлнэ.

**ҮНБ=ДНБ+ДО+ГО**

**ДО**- гадаадад суугаа тухайн улсын иргэдийн үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний мөнгөн дүн

**ГО**- тухайн улсад суугаа гадаадын иргэдийн үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний мөнгөн дүн

# Далд эдийн засаг

Албан ёсны тооцоо хяналтаас гадуурх эдийн засгийн үйл ажиллагаа буюу үйлчилгээг хэлнэ.

Өрхийн аж ахуй- мансууруулах бодис, татвараас зайлсхийх, мэдээлэл арилжаа  
Хар зах- мөнгөн угаах, хүүлэх, Валютын арилжаа, Эмчилгээ сувилгаа  
Хууль бус бүлэглэл-Үйлчилгээ, Тээвэр, Хуурамч бичиг баримт

## **Далд эдийн засгийн үр дагавар:**

Бодит эдийн засгийн алдагдал, татвар, нийгмийн даатгал, эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, амралтын цаг ашиглалтаар хохирдог. Эерэг тал нь нийгэм дэх ажилгүйдэл, ядуурал буурна.




## Хяналтын асуулт, даалгавар:

Тохируулна уу

а. Нэн ядуу	1. Хувь хүн, гэр бүл хооол хүнс хувцас, сууцтай байхад хүрэлцэхүйц орлого гэж ЗГ-с тогтоосон
б. Туйлын ядуу	2. Ядуурлын босгон доор амьдарч байгаа хүн амын эзлэх хувь
в. Ядуурлын босго	3. Ядуугийн доод түвшин
г. Ядуурлын коэффициент	4. ЗГ-с тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшнээс 40%иас доош


## Хяналтын асуулт, даалгавар:

1. Нэмүү өртөг гэж юуг хэлэх вэ?
2. Нийгмийн бүх гишүүдийн амьдралын хэвийн нөхцлийг хангахад чиглэгдсэн улс төр, эдийн засаг, эрх зүйн харилцааны цогцийг...
3. Ядуучууд бусдаас хэрхэн доогуур амьдарч байгааг харуулах үзүүлэлт...
  - а. Хэрэгцээний ядуурал
  - б. Үнэлгээний ядуурал
  - в. Туйлын ядуурал
4. Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, цалин, хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйлдвэржүүлэх үйл ажиллаа нь ажилгүйдлийг бууруулах ямар арга хэмжээ вэ?



## Эх сурвалж:

1. “Нийгэм судлал” хичээлийн ерөнхий боловсролын сурах бичгүүд
2. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
3. Орчуулсан Б.Батчулуун “Философи”. УБ., 2012
4. О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг “Нийгмийн ухаан”. УБ., 2012
5. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014



**Анхаарал хандуулсанд баярлалаа.**

